



Ulaanbaatar

United States Embassy



The Open Range

The ART in Embassies Program

Cover: (Detail)
David Halbach
Forewarned, 2004
Watercolor on paper
25 1/2 x 22 1/2 in.

Хавтас (деталь):
Дэвид Халбак
Сэрэмжлүүлэх дохио, 2004
Усан будаг, цаас
64,8 x 57,2 cm



Ambassador Pamela J. Slutz and Ronald J. Deutch
Элчин сайд Памела Слutz болон Роналд Датч

The Open Range

It is our great pleasure to welcome you to the Residence of the United States Embassy in Ulaanbaatar. We hope that you enjoy this unique exhibition of art of the American West, particularly our little corner of it, Texas.

As we contemplated our selections of American art, we were struck by how much Mongolia looks and feels like our native Texas: vast, rolling landscapes, and grazing herds of animals, watched over by men on horses. In the not-too-distant past, semi-nomadic cowboys drove large herds of cattle across the open range in much of Texas. Today cattle ranching – so important to the economic development of the early American West – and the cowboy ethos – so integral to the American spirit – continue to influence the lives of contemporary Texans. Mongolians will see in some of the paintings a striking similarity to Mongolia’s rolling steppe land, dotted by animals, and watched over by self-reliant nomadic herders astride their hardy ponies.

Mongolians and Native Americans are beginning to explore their common ancestry. Stimulated by cultural exchanges in the past few years, contemporary Native Americans and Mongolians have re-discovered that they share deep roots, including a love of the land, nature, and a deep spirituality. Some of the pieces in the exhibition will evoke in Mongolians a recognition of their own cultural heritage.

We are particularly pleased to collaborate with The Museum of Western Art in Kerrville, Texas, and its Executive Director, Richard Assunto, who worked with us and the contributing artists to shape this collection of American Western art. Included in it are works by several members of the Cowboy Artists of America, an association committed to depicting the timeless heritage of the American West.

Finally, we would like to thank the staff of the U.S. Department of State’s ART in Embassies Program for their dedication, patience, and professionalism in curating, shipping, and documenting the exhibition that you see today.

Ambassador Pamela J. Slutz and Ronald J. Deutch

*Ulaanbaatar
August 2004*

Уудам тал

Та бүхнийг Улаанбаатарт суугаа АНУ-ын Элчин сайдын өргөөнд морилон саатахыг урихын ялдамд энд тавигдсан Америкийн баруун хязгаар, ялангуяа бидний төрөлх нутаг Техасын уран бүтээлчдийн өвөрмөц үзэсгэлэнг таашаан соёрхоно гэдэгт итгэж байна.

Бид үзэсгэлэндээ зориулан Америкийн урлагийн бүтээлүүдээс сонголт хийж байхдаа Монгол орон бидний төрөлх Техас нутагтай үнэхээр адилхан болохыг харж гайхан биширч билээ. Өргөн уудам тал, байгалийн гоо үзэсгэлэн, идээшилж буй мал сүрэг, түүний дэргэд морь унасан малчин эр . . . Хагас нүүдэлчин ковбойчууд Техасын уудам талд их хэмжээний үхэр малаа туун ирж суурьшсан нь тийм ч олон зууны тэртээд биш ажгуу. Америкийн баруун хязгаарын эдийн засгийн эхэн үеийн хөгжилд маш чухал үүрэг гүйцэтгэсэн үхрийн аж ахуй, мөн Америк төрхийн салшгүй нэг хэсэг болох ковбойчуудын соёл өнөөдөр ч гэсэн Техасчуудын амьдралд нөлөөтэй хэвээр байна. Монголчууд эдгээр зургийн заримаас мал сүрэг налайн бэлчсэн монголын тал нутаг, түүний дээгүүр хараа сунган буй морьтон зэргийг олж хараад адил төстэйг нь гайхах буйзаа.

Монголчууд болон уугуул америкчууд гарал үүсэл нэгтэйгээ судалж эхэлж байна. Сүүлийн хэдэн жилд хийгдсэн соёлын солилцооны үрээр орчин үеийн уугуул америкчууд болон монголчууд гарал язгуур, газар нутаг, байгал дэлхийгээ хайрлах үзэл, гүн гүнзгий сүсэг бишрэл гэх зэргээр хоорондоо олон зүйлээр адилхан байгаагаа олж мэдсэн юм. Энэ үзэсгэлэнд тавигдсан зарим бүтээлүүд монголчуудад өөрсдийнх нь соёлын өвийг санагдуулам байх болно.

Америкийн Вестэрн урлагийн энэхүү цуглуулгыг эмхэлж бүрдүүлэхэд гүн тусалцаа үзүүлсэн Техас мужийн Кервилл дэх Вестэрн урлагийн музей, түүний гүйцэтгэх захирал Ричард Ассунто болон уран бүтээлээ хандивласан зураач, барималч нартай хамтран ажиллахад маш таатай байлаа. Үзэсгэлэнд Америкийн баруун нутгийн давтагдашгүй өв соёлыг дүрслэн үлдээх эрхэм зорилго бүхий Америкийн ковбой зураачдын холбооны гишүүн хэд хэдэн уран бүтээлчийн бүтээлүүд орсон байгаа.

Эцэст нь, та бүхний өнөөдөр үзэж буй энэхүү бүтээлүүдийг хадгалж хамгаалах, нааш нь илгээх, үзэсгэлэн болгон тавих ажилд үнэнч, тэвчээртэй хандаж, мэргэжлийн ур чадвар гарган ажилласан АНУ-ын Төрийн департаментын «ЭСЯмд дахь уран зураг» хөтөлбөрийн ажилтнуудад талархаж буйгаа илэрхийлье.

Элчин сайд Памела Слуц болон Роналд Датч

Улаанбаатар
2004 оны 8-р сар

The Museum of Western Art

We at the Museum of Western Art are pleased to be able to participate in the ART in Embassies Program. Our museum's objective is not only to display fine art, but also to provide the public with educational experiences about the American West . . . its people, its settlement, and its history. To reflect the infinite diversity of this celebrated region of our country and its inhabitants – the Native Americans and the cowboys – we have provided examples of art in a variety of media: oil paint, watercolor, and bronze.

The works of art in the exhibition reflect different perspectives based upon the life experiences of the artists who created them. But the artists share one common trait: each is well acquainted with his or her subject matter as all of them have either owned ranches, worked as ranch hands, or acquired firsthand knowledge of their subject matter through thorough research. The principle hallmark of the artists' work is their dedication to accurately and realistically depict a bygone time and place whose history and legend still loom large in the American consciousness, affecting the way in which we perceive ourselves – and the way that the world perceives us.

As you reflect on the artwork in this exhibition, we hope that you will come to appreciate the struggles and triumphs of these early Western cowboys, eking out an existence in a rough and tumble frontier environment that challenged them body and soul. But perhaps more importantly, we hope that the exhibition impresses upon you a sense of mankind's universal desire to not only survive, but to flourish, as well as the hopes and dreams that we all share for a better life.

Richard Assunto, Guest Curator
Director, The Museum of Western Art
Kerrville, Texas
September 2004

Вэстэрн урлагийн музейн

Вэстэрн урлагийн музейн хамт олон бид «ЭСЯмд дахь Уран зураг» хөтөлбөрт оролцож байгаадаа туйлын баяртай байна. Манай музейн зорилго бол зөвхөн урлагийн бүтээлүүдийг дэлгэн үзүүлээд зогсохгүй Америкийн баруун хязгаар, түүний түүх, суурьшил, хүмүүсийн тухай мэдээллийг олон нийтэд хүргэхэд оршдог юм. Манай орны энэхүү алдар цуутай бүс нутаг болон тэндхийн оршин суугч уугуул Америкчууд, ковбой нарын давтагдашгүй өв соёлыг харуулахын тулд бид төрөл бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тосон ба усан будгийн зураг, уран баримлуудыг сурталчилж байсан билээ.

Энэ үзэсгэлэнд тавигдсан бүтээлүүд тэдгээрийг хийсэн уран бүтээлчдийн амьдралын туршлагаас шалтгаалан янз бүрийн үзэл санааг илэрхийлжээ. Гэхдээ эдгээр уран бүтээлчдэд нэг нийтлэг чанар бий. Тэд бараг бүгдээрээ эсвэл ранчотой, эсвэл тэнд ажиллаж үзсэн, эсвэл сэдвээ маш сайн судалж, гүн гүнзгий мэддэг болсон байна. Эдгээр бүтээлийн онцлог шинж нь бид өөрсдийгөө болоод дэлхий биднийг хэрхэн ойлгоход нөлөөлж байдаг тэрхүү Америк сэтгэлгээнд одоо болтол илэрсээр байдаг өмнөх цаг үе, газар нутгийн домог түүхийг нягт нямбай, бодитоор дүрслэн үзүүлэхийг зорьсонд байгаа юм.

Энэхүү үзэсгэлэнг үзээд та бүхэн бие, сэтгэлийн тэнхээ шалгасан буйд хязгаарын хүнд бэрх нөхцөлд амьдрахын төлөө зовж зүдэрч явсан Баруун хязгаарын ковбой нарын тэмцэл, ялалтыг бахдах болно. Гэхдээ хамгийн гол нь зөвхөн амьдрах бус бас хөгжиж цэцэглэх гэдэг хүн төрөлхтний нийтлэг хүсэл, сайн сайхан амьдралын тухай итгэл, мөрөөдлийг энэ үзэсгэлэнгээс олж харах байх гэж бид найдаж байна.

Ричард Ассунто, зөвлөх

Техас мужийн Кервилл дахь Вэстэрн урлагийн музейн захирал

2004 оны 9-р сар

The ART in Embassies Program

The ART in Embassies Program is a unique blend of art, diplomacy, politics, and culture. Regardless of the medium, style, or subject matter, art transcends barriers of language and provides the means for ART to achieve its mission: to promote dialogue through the international language of art that leads to mutual respect and understanding between diverse cultures.

Modestly conceived in 1964, this visual diplomacy initiative has evolved into a sophisticated program that curates exhibitions, managing and exhibiting more than 3,500 original works of loaned art by United States citizens. The work is displayed in the public rooms of some 180 U.S. embassy residences and diplomatic missions worldwide. These exhibitions, with their diverse themes and content, silently yet persuasively represent one of the most important principles of our democracy: freedom of expression. The art is a great source of pride to U.S. ambassadors, assisting them in multi-functional outreach to the host country's educational, cultural, business, and diplomatic communities.

Works of art exhibited through the program encompass a variety of media and styles, ranging from eighteenth century colonial portraiture to contemporary glass sculpture. They are obtained through the generosity of lending sources that include U.S. museums, galleries, artists, institutions, corporations, and private collectors. In viewing the exhibitions, the thousands of guests who visit U.S. embassy residences each year have the opportunity to learn about our nation – its history, customs, values, and aspirations – by experiencing firsthand the international lines of communication known to us all as art.

The ART in Embassies Program is proud to lead this global effort to present the artistic accomplishments of the people of the United States. We invite you to visit the ART web site, <http://aiep.state.gov>, which features on-line versions of all exhibitions worldwide, and hyperlinks with artists and lenders.

«Элчин сайдын яамд дахь уран зураг» хөтөлбөр

«Элчин сайдын яамд дахь уран зураг» хөтөлбөр нь урлаг, соёл, улс төр, дипломат харилцааны маш өвөрмөц хослол юм. Урлаг бол арга хэрэгсэл, хэв маяг, сэдэв зэргээс хамааралгүй, үг яриагаар илэрхийлснээс илүүтэйгээр олон улсын урлагийн хэлээр ярилцаж, хоорондоо ялгаатай соёлууд харилцан бие биенээ хүндэтгэж, ойлголцох замыг нээж өгдөг билээ.

1964 онд даруухан эхэлсэн энэ дипломат санаачлага одоо АНУ-ын иргэдийн хандивласан 3500 гаруй урлагийн эх бүтээлээс бүрдэх үзэсгэлэнгүүдийг зохион байгуулж, дэлгэн үзүүлдэг томоохон хөтөлбөр болж өргөжжээ. Эдгээр бүтээлүүдийг дэлхийн 180-аад оронд суугаа АНУ-ын Элчин сайдын яамд, дипломат төлөөлөгчийн газруудын байрны олон нийтэд нээлттэй байдаг хэсэгт дэлгэн үзүүлдэг юм. Сэдэв, агуулгын хувьд ялгаатай эдгээр үзэсгэлэнгүүд аядуухан боловч итгэлтэй байдлаар манай ардчилалын хамгийн чухал зарчмуудын нэг болох өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөний бэлгэдэл болж байдаг. Урлагийн энэхүү бүтээлүүд нь АНУ-ын элчин сайдуудын хувьд ихээхэн бахархал төрүүлдэг зүйл бөгөөд тухайн суугаа орныхоо боловсрол, соёл, бизнесийн болон дипломат хүрээнийхэнд өөрийн орноо таниулан суртчилахад нь тусалдаг юм.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дэлгэн тавигдсан урлагийн бүтээлүүд нь 18-р зууны үеийн дээдсийн хөрөг зургаас эхлээд орчин үеийн шилэн баримал хүртэл арга хэрэгсэл, хэв маягийн хувьд маш олон янз байдаг. Эдгээр нь АНУ-ын музей, галерей, уран бүтээлчид, байгууллага, корпорацууд болон хувийн цуглуулгаас өгөөмөр сэтгэлээр хандивласан бүтээлүүд юм. Жил бүр АНУ-ын Элчин сайдын яамдын байранд зочилж, энэхүү үзэсгэлэнгүүдийг үздэг мянга мянган хүмүүс манай үндэстэн, бидний түүх, зан заншил, үнэт зүйлс, зорилгын тухай улс үндэстэн хоорондын харилцааны хэрэгсэл болох урлагаар дамжуулан олж мэдэх боломжтой байдаг билээ.

«Элчин сайдын яамд дахь уран зураг» хөтөлбөрийнхөн АНУ-ын ард түмний бүтээсэн урлагийн бүтээлүүдийг дэлхий нийтэд танилцуулах энэхүү ажлыг удирдан зохион байгуулж байгаадаа сэтгэл хангалуун байдаг. Та бүхэн манай <http://aiep.state.gov> сайтад зочилж, дэлхий даяар тавигдсан үзэсгэлэнгүүдийн он-лайн хувилбарыг үзэж сонирхон, уран бүтээлчид, цуглуулгаасаа зураг бүтээл хандивласан хүмүүстэй танилцаарай.

Wayne Baize (born 1943)

Reluctant Mount depicts cowboys rounding up horses, to later use on the ranch to round up cattle and herd them to the railhead for sale.

Wayne Baize was born, raised, and is still a Texan. The son of a cotton and wheat farmer, Baize displayed early artistic talent that did not go unnoticed by his parents, who enrolled him in private art lessons from the ages of twelve to seventeen. His professional career began in 1966 with his first one-man show in the lobby of a savings and loan. It was a sell-out, and ever since, Baize has made a living from his art. One year later, he met Cowboy Artists of America member Tom Ryan, who became not only a mentor, but also an inspiration. Baize followed in Ryan's footsteps, and was invited to join the organization in 1995.

Baize describes his artistic style as “semi-loose” with a palette that tends toward earth tones. He hastens to add that his true love in all of paintings is animals. He jokes that “The only reason I put people in my paintings is to provide an excuse to paint the animals.”

Уэйн Бэйз (1943)

Эмнэг хангал нэртэй энэ зурагт төмөр замын өртөөн дээр мал туун аваачиж зарахаар зэхэн адуугаа хурааж буй ковбойчуудыг дүрсэлжээ.

Уэйн Бэйз Техас мужид төрж өссөн бөгөөд одоо ч тэндээ амьдардаг. Хөвөн, улаан буудай тариалдаг фермерийн хүү Бэйзийн зурах авьяас эрт илэрсэн бөгөөд эцэг эх нь түүний авьяасыг анзаарч, 12–17 нас хүртэл нь хувийн багшаар зургийн хичээл заалгажээ. Түүний мэргэжлийн зам нь 1966 онд хадгаламж, зээлийн хоршооны үүдний коридорт бие даасан үзэсгэлэнгээ дэлгэн тавьснаар эхэлжээ. Тэдгээр зургууд нь бүгд зарагдсан бөгөөд түүнээс хойш зургаараа амьдарсаар байна. Нэг жилийн дараа тэрбээр Америкийн Ковбой Зураачдын холбооны гишүүн Том Райантай танилцсан нь зөвхөн зөвлөгч төдийгүй урам зориг өгдөг хүнтэй болсон юм. Бэйз мөн Райаны замаар замнаж, 1995 онд дээрх холбооны гишүүнээр элсэх урилга авсан байна.

Бэйз өөрийн уран зургийн арга барилаа газрын өнгө давамгайлсан «чөлөөт маягийн» гэж тодорхойлдог. Түүний зурах хамгийн дуртай зүйл бол амьтад гэж тэр яаран нэмж хэлэх вий. «Би зургандаа хүмүүсийг оруулдаг ганцхан шалтгаан бол амьтан дандаа зурдгийнхаа төлөө уучлалт хүсэх гэсэн л хэрэг» гэж тэр хошигнодог.



***Reluctant Mount*, 2004**

Oil on canvas

31 ³/₄ x 47 ³/₄ in.

Courtesy of the artist and

The Museum of Western Art, Kerrville, Texas

***Эмнэг хангал*, 2004**

Тосон будаг, зотон

80,6 x 121,3 см

Техас мужийн Кервилл дахь Вестэрн
урлагийн музей болон уран бүтээлчийн бэлэг

Lenell Deane (born 1958)

“This bronze depicts the typical regalia used by Crow women for their horses. The horse harness, saddle, and hangings are buckskin covered in red trade cloth, and embellished with intricate beadwork in a typical Crow pattern.”

Lenell Deane

Preparations for the survival and longevity of all Plains warriors began before they were born. During pregnancy, either the mother or one of the grandmothers would make two curious quilled or beaded objects, a sand lizard and a turtle. Both animals were revered because they “lived forever” and were difficult to kill. Their protective powers were enlisted early as guardians and grantees of the individual’s long life. When the child was born, the umbilical cord was cut, placed inside the turtle, and packed in tobacco or herbs, while the lizard served as a decoy to lure away malevolent forces.

Excerpt from *The Mystic Warriors of the Plains: The Culture, Arts, Crafts and Religion of the Plains Indians*, Thomas E. Mails. BDD Promotional Books Company, 1993.

Lenell Deane’s sculptures convey the quiet and forgotten moments of life in the West. Deane’s interest in this subject matter is a natural outgrowth of her past. As a native of south Texas, her family’s ranching interests were part-and-parcel of her upbringing. Born in Corpus Christi, Texas, Deane spent her childhood “going to the ranch” run by her two uncles. For years, she struggled to find a way to give expression to the stories inside her. Writing, oil painting . . . none of it seemed to satisfy. Finally, she attended a two-day workshop on sculpting. “Of course, this was IT, the thing I had been searching for. The huge thing was able to come out. I could express the things I felt and experienced.”

Deane has won Best of Show from the Coppini Academy of Fine Arts in San Antonio, Texas. She was named Artist of the Year in Kerrville, Texas, and has won First Place honors from the Texas Hill Country Arts Foundation. Most recently, she received the Miller-Johnson Award for Three-dimensional Work from the Bosque County Conservatory of Art, Clifton, Texas, and the Leonard J. Meiselman Memorial Award from the Salmagundi Club in New York City. Deane also took First Place in sculpture at the 24th Annual Phippen Western Art Show in Prescott, Arizona. She currently works out of her studio on her ranch in Kerrville, Texas.

Лэнэл Дийн (1958)

«Энэхүү хүрэл баримал нь Кроу омгийн эмэгтэйчүүдийн морь унахдаа хэрэглэдэг эд хэрэглэлийг дүрсэлжээ. Морины тоног, эмээл, чимэглэл зэргийг зузаан ширээр хийж, үнэтэй улаан даавуугаар бүрээд Кроу маягийн хээ бүхий нарийн ур хийцтэй хатгамлаар чимдэг».

Лэнэл Дийн

Талын омгийн дайчдын амьд үлдэх, урт удаан наслах бэлтгэлийг бүр төрөхөөс нь өмнө хийж эхэлдэг байв. Хүүхдийг эхийнхээ хэвлийд байхад ээж нь, эсвэл аль нэг эмээ нь үхэр зарааны өргөсөөр зүү хийж элсний гүрвэл болон яст мэлхий урладаг байв. Энэ хоёр амьтан хоёулаа урт насалдаг бөгөөд хорооход амаргүй учраас их хүндлэгддэг ажгуу. Урт наслахын баталгаа болгож хамгаалах хүчийг нь эрт дуудаж буй нь тэр. Хүүхдийг төрөхөөр хүйг нь тасалж, яст мэлхийн дотор хийгээд тамхины навч болон ургамал чихдэг бол гүрвэл нь хорон муу хүчийг зайлуулна гэж үздэг байв.

Томас И. Мэйлз. *Талын омгийн домогт дайчид: Тал нутгийн индианчуудын соёл, урлаг, гар урлал, шашин номноос*. BDD Promotional Books Company, 1993.

Лэнэл Дийний барималууд нь баруун хязгаар дахь амьдралын чимээгүй бөгөөд мартагдсан мөчүүдийг дүрсэлдэг. Энэ сэдвийг сонирхох болсон нь Дийний туулсан амьдралтай холбоотой. Өмнөд Техаст төрсөн Дийний хүүхэд насны салшгүй нэгэн хэсэг нь түүний гэр бүлийн эрхэлдэг ранчо байв. Техас мужийн Корпус Кристид төрсөн тэрвээр хоёр авгынхаа ранчод бага насаа өнгөрөөсөн бөгөөд багаас нь хадгалагдаж үлдсэн тэрхүү дурсамжуудыг илэрхийлэх арга замыг нилээд хэдэн жил хайсан гэдэг. Бичиж, зурж үзсэн боловч аль нь ч санаанд нь хүрсэнгүй. Хамгийн сүүлд нь уран баримлын хичээлд хоёр өдөр сууж үзжээ. «Миний хайж байсан зүйл энэ мөн байлаа. Миний дотор байсан тэр агуу том зүйл гадагшаа гарах боломжтой боллоо. Би өөрийн мэдэрч, үзэж байсан зүйлээ илэрхийлж чадахаар болсон» гэж тэр хэлжээ.

Дийн Техас мужийн Сан Антонио дахь Дүрслэх урлагийн Коппини Академийн дээд шагналыг хүртсэн байна. Мөн Техас мужийн Кервилл хотын Оны тэргүүний уран бүтээлч болж, Техас Хилл Кантри Урлагийн сангаас тэргүүн байрны шагнал авсан байна. Хамгийн сүүлд Техас муж, Клифтоны Боск дүүргийн Дүрслэх урлагийн сургуулиас Гурван хэмжээст бүтээлд олгодог Миллер-Жонсоны шагнал, мөн Нью-Йорк хотын Салмагүнди клубээс Леонард Ж. Мэйзилманы дурсгалын шагналыг авсан байна.



The Gift, 2000

Bronze

17 1/2 x 12 3/4 x 10 1/2 in.

Courtesy of the artist and

The Museum of Western Art, Kerrville, Texas

Бэлэг, 2000

Хүрэл

44,5 x 32,4 x 26,7 см

Техас мужийн Кервилл дахь Вестэрн урлагийн музей болон уран бүтээлчийн бэлэг

Дийн мөн Аризона мужийн Прескот хотод болсон Фиппен Вестэрн Урлагийн 24 дэх удаагийн наадмаас уран баримлын төрөлд тэргүүн байр эзэлжээ. Одоо тэрээр Техасын Кервиллд байх ранчо дахь урландаа уран бүтээлээ туурвиж байна.

Donald Gray (born 1948)

Entitled *Bill, an Oregon Cowboy*, this work was created in honor of Donald Gray's friend by the same name, depicted sitting confidently in the saddle and surveying the terrain around him.

Gray credits his earliest inspiration to the landscape of his childhood in rural northeast Oregon. He studied art at Eastern Oregon University in La Grande, training his eye and hand in traditional techniques that result in meticulously rendered, realist paintings. After graduating in 1970, Gray taught high school art for one year before beginning his professional art career. In 1978 he formed a partnership, Bear Wallow Publishing, with writer Rick Steber and photographer Jerry Gildemeister. Their co-creation, *Traces*, published in 1980, documented the last surviving travelers of the Oregon Trail.

In the mid-1980s Gray's realistic style began to change as he experimented with a more spontaneous approach. His current work combines the traditional with a more contemporary idiom.

Gray has exhibited in galleries and museums throughout the United States. He has taught occasional workshops and college level courses, painted indoor and outdoor murals in several states, and illustrated over twenty books. He lives and works in Murrieta, California.

Доналд Грей (1948)

Орегоны ковбой Билл хэмээх энэхүү зургийг Доналд Грей өөрийн найз Биллдээ зориулж бүтээсэн бөгөөд эмээл дээрээ итгэлтэй нь аргагүй сууж, орчин тойрноо ажиглан харж буйгаар дүрсэлжээ.

Зүүн хойд Орегоны хөдөө нутагт хүүхэд насаа өнгөрөөсөн нь байгалийн үзэсгэлэнг багаасаа мэдрэхэд нөлөөлсөн гэж Грей үздэг. Тэрээр Ла Гранд дахь Зүүн Орегоны Их сургуульд уран зураг судалсан бөгөөд уламжлалт техникт нүд, гараа дасган хичээллэсний үр дүнд маш нарийн дүрслэл бүхий реалист зургууд зурж байв. 1970 онд сургуулиа төгсөөд мэргэжлийн зураачийн гараагаа эхлэхээс өмнө нэг жил ахлах сургуульд зургийн хичээл заасан байна. 1978 онд тэрээр зохиолч Рик Стэбэр, гэрэл зурагчин Жерри Гилдэмайстер нартай хамтран Bear Wallow Publishing нэртэй нэгдлийг үүсгэн байгуулсан бөгөөд 1980 онд хэвлэгдсэн тэдний хамтын бүтээл болох *Ул мөр* нь Орегоны цуваанаас амьд үлдсэн сүүлчийн аялагчдын тухай баримт байлаа.

1980-аад оны дунд үеэс Грей илүү чөлөөтэй арга барицыг турших болсноор реалист хэв маяг нь өөрчлөгдөж эхэлсэн. Түүний энэ бүтээл нь уламжлалт зургийг орчин үеийн хэв маягтай арай түлхүү хослуусан бүтээл юм.

Грей Америк орон даяар галерей, музейнуудад үзэсгэлэнгээ гаргасан байна. Тэрээр хааяа дугуйлан, коллежийн түвшний хичээл зааж, хэд хэдэн мужид гадна болон дотор ханын зураг зурж, хорь гаруй номын зураг чимэглэлийг хийжээ. Одоо Калифорни мужийн Муриета хотод амьдарч, уран бүтээлээ туурвиж байна.



Bill, an Oregon Cowboy

Oil/alkyd on canvas

30 x 41 in.

Courtesy of the artist and The Museum of Western Art,
Kerrville, Texas

Орегоны ковбой Билл

Тосон будаг, зотон

76,2 x 104,1 см

Техас мужийн Кервилл дахь Вэстэрн урлагийн
музей болон уран бүтээлчийн бэлэг

David Halbach (born 1931)

“American Plains Indians had little concern with the mountain man. Occasionally incidents occurred, but for the most part, mountain men traded with, lived with, and sometimes married into Plains tribes. As America’s Civil War ended, around the third quarter of [the] 1800s, U.S. soldiers were sent west to open new territory for white settlers. This work depicts an Indian who has uncovered a military canteen, perhaps lost by a soldier in his rush to keep up with the column. The Indian may not know what it is he has found nor the implications for him and all Indians . . . but it is a ‘forewarning’ of what is to come.”

David Halbach

David Halbach wanted to be an artist for as long as he can remember. He completed his first painting when he was in sixth grade, and in junior high school, he discovered he had real talent. After that he just kept on painting. He attended the Chouinard Art Institute in Los Angeles. After finishing art school and a tour in the Navy, he went to work as an animator for Walt Disney Studios, working on *Lady and the Tramp*. He then entered commercial art and became an art teacher, which allowed him to create fine art and refresh his knowledge of the basics. Eventually, Halbach moved to Arizona where he has achieved success as a watercolorist.

The artist extensively researches subjects for his work. He says, “There is a lot of truth in ‘paint what you know.’” Living in Arizona, Halbach began to investigate the history of the West and all that was needed to make his work honest and correct. That investigation brought to mind the many times he had played “cowboys and Indians” when he was young. According to Halbach, “A child’s imagination is an important asset to an artist. It mustn’t be lost.”

Halbach won numerous awards while showing in various invitational shows throughout the 1960s and 1970s. At his first invitation to the National Cowboy Hall of Fame show, he won the prestigious Silver Medal for his watercolor *Story Teller*. In 1985 he was inducted into the Cowboy Artists of America (CAA). Since then, he has won the CAA’s coveted Gold Medal for watercolor five times, and has received the Silver Medal five times. In 1985 his painting entitled *Chippawa Hunter* won the

Дэвид Халбак (1931)

«Америкийн тал нутгийн индианчууд уулынхантай жирийн л харилцаатай байв. Хааяа нэг муудалцах зүйл байдаг ч ихэнхдээ уулынхантай наймаа хийж, хамт амьдарч, заримдаа бүр хоорондоо гэрлэх ч тохиолдол байв. Америкийн иргэний дайны дараа, 1860-аад оны үед цагаан арьстнууд суурьших шинэ газар нутаг нээхээр америк цэргүүдийг баруун зүг рүү илгээжээ. Энэхүү бүтээлд хэн нэгэн цэрэг жагсаалаа гүйцэх гэж яарч байхдаа хаячихсан бололтой цэргийн дашмагийг дөнгөж олоод буй индиан хүнийг дүрсэлжээ. Түүний олсон зүйл чухам юу болох, индианчуудын хувьд энэ нь ямар утга агуулж буйг энэ индиан хүн мэдэхгүй ч энэ нь ямар нэг зүйлийг «урьдчилан сануулаад» байх шиг . . .

Дэвид Халбак

Дэвид Халбак бүр багаасаа л зураач болохыг хүсдэг байв. Тэрээр 6-р ангид байхдаа анхны зургаа зурж дуусгасан бөгөөд ахлах сургуульд байхдаа өөрийгөө жинхэнэ авъяастай болохыг мэджээ. Түүнээс хойш зүгээр л зураад байж. Тэрээр Лос Анжелес хотын Chouinard уран зургийн сургуульд суралцаж төгсөөд тэнгисийн цэрэгт алба хаасныхаа дараа Уолт Дисней студид *Хатагтай ба тэнүүлч* хүүхэлдэйн киноны зураачаар ажиллахаар очжээ. Дараа нь урлагийн бизнест хөл тавьж, зургийн багш болсон бөгөөд энэ нь түүнд бүтээлээ туурвихын зэрэгцээ зургийн үндсэн мэдлэгээ сэргээхэд тус болж байв. Тэгээд Аризонад нүүж очсоныхоо дараа усан будгийн төрлөөр их амжилт олсон байна.

Тэрээр бүтээлээ туурвихын тулд маш их судалгаа хийдэг. «Өөрийн мэддэг зүйлээ зурвал илүү үнэмшилтэй болдог» гэж тэр хэлдэг. Аризонад байхдаа Дэвид Халбак баруун хязгаарын түүхийг судалж эхэлсэн нь бүтээлүүдээ үнэн, бодитой болгохын тулд хийсэн зүйл байв. Энэхүү судалгаа нь багадаа «ковбой, индиан» гэж тоглодог байсныг нь эргэн санагдуулсан байна. Түүний хэлснээр «хүүхэд насны төсөөлөл бол зураач хүнд маш их хэрэгтэй зүйл бөгөөд түүнийг хадгалж байх ёстой» юм байна.

1960–70-аад онд Халбак янз бүрийн үзэсгэлэнд уригдан оролцож, хэд хэдэн шагнал хүртжээ. Үндэсний Ковбой зургийн үзэсгэлэнд анх уригдаж оролцоходоо тэрээр *Үлгэрч* гэдэг усан будгийн зургаараа нэр хүндтэй мөнгөн медалийн эзэн болсон бөгөөд 1985 онд Америкийн Ковбой Зураачдын холбоонд элсжээ. Түүнээс хойш усан будгийн зургаараа тус холбооны нэр хүндтэй шагнал болох

purchase award at the Buffalo Bill Historical Center in Cody, Wyoming, and in 1989, the Southwest region's Arts for the Parks competition awarded Halbach first place. Sponsored by the National Park Academy of the Arts, the program is designed to celebrate representational artists, to enhance public awareness of the National Parks, and to contribute to programs benefiting the National Park System. The annual competition honors artists who have best captured the spirit of our National Park System.

Halbach was honored in 1990 with the Western Heritage Award. Given by Favell Museum of Kalamath Falls, Oregon, this award celebrates watercolorists who demonstrate excellence in portraying the West, past and present. His painting, *Heading Out*, appears in *The West, A Treasure of Art and Literature* by Watkins & Watkins.

алтан медалийг 5 удаа, мөнгөн медалийг 5 удаа хүртсэн байна. 1985 онд *Чиппава анчин* зургаараа Вайоминг мужийн Коди хотын Баффало Биллийн түүхийн төвд зургаа худалдах эрхээр шагнуулсан бол 1989 онд Баруун өмнөд бүсийн Arts for the Parks уралдааны тэргүүн байрыг эзэлсэн байна. Үндэсний Паркийн Урлагийн Академиас ивээн тэтгэж явуулдаг энэ хөтөлбөр нь байгалийн сэдвээр зурдаг зураач нарыг цуглуулж, Үндэсний паркуудыг олон нийтэд таниулах, Үндэсний паркийн системд ашиг тустай хөтөлбөрүүдэд нэмэр болох зорилготой юм. Жил бүр явагддаг энэ уралдаан Үндэсний Паркийн Системийн онцлог төрхийг сайн дүрсэлж чадсан зураач нарыг шалгаруулдаг.

1990 онд Халбак «Баруун хязгаарын өв» шагналыг хүртжээ. Орегон мужийн Каламат Фоолз дахь Фэйвэл музейгээс олгодог энэ шагналыг Баруун хязгаарын өнгөрсөн ба одоо үеийг чадварлаг дүрсэлсэн усан будгийн зураач нарт өгдөг юм. Түүний *Ажилдаа гарлаа* нэртэй зураг нь Уоткинс ба Уоткинсын «Баруун нутгийн урлаг, уран зохиолын эрдэнэсийн сан» номонд орсон байна.



Forewarned, 2004

Watercolor on paper
25 1/2 x 22 1/2 in.

Courtesy of the artist and The Museum of Western Art,
Kerrville, Texas

Сэрэмжлүүлэх дохио, 2004

Усан будаг, цаас
64,8 x 57,2 см

Техас мужийн Кервилл дахь Вэстэрн урлагийн музей болон
уран бүтээлчийн бэлэг

Harvey William Johnson

(born 1921)

Harvey W. “Bud” Johnson was born in New York City in 1921, but moved to California when he was a year old. His father died when he was six, and the family returned East. Johnson dropped out of high school just before graduating, and joined the U.S. Army Corps of Engineers. In the Army he earned his high school diploma, and after World War II, he enrolled at the Art Students League in New York City, as had his parents thirty years before.

For almost nineteen years, Johnson was an instructor at the Famous Artists School in Westport, Connecticut. During that time he also produced hundreds of illustrations for pulp magazines. Although the subjects of this work varied widely, the majority of the manuscripts he illustrated were Westerns. Eventually he became totally dedicated to Western subject matter, moving to New Mexico, where he lives in an adobe house overlooking the Santa Fe Trail. The artist is meticulous in researching his work, traveling to the site of many of his paintings in order to make certain that both the Western gear and clothing as well as the local vegetation and topography are accurately depicted.

As a charter member of the Cowboy Artists of America, Johnson has served the organization as both president and vice-president. In 1978 and 1979 his oils won silver medals at the annual Cowboy Artists of America Exhibition in Phoenix, Arizona. He has exhibited at the Grand Palais in Paris, and his paintings are included in numerous public and private collections in this country, as well as in Mexico and Europe. Johnson has been the subject of many magazine articles, and his paintings have appeared in several books.

Харвэй Уильям Жонсон

(1921)

Харвэй Уильям Жонсон 1921 онд Нью-Йорк хотод төрсөн боловч түүнийг нэг настай байхад гэр нь Калифорнид нүүж очжээ. Түүнийг 6 настай байхад эцэг нь нас барсан учир тэднийх буцаад зүүн тийшээ нүүсэн байна. Жонсон ахлах ангиа төгсөхийн өмнөхөн сургуулиа орхиж АНУ-ын армийн Инженерийн ангид оржээ. Армид алба хааж байхдаа ахлах сургуулийн үнэмлэхээ авч, Дэлхийн 2-р дайн дууссаны дараа тэрээр 30 жилийн өмнө эцэг эхийнхээ элсэж байсан Нью-Йорк хотын Урлагийн оюутнуудын лигт элсэн орсон байна.

Жонсон бараг 19 жилийн турш Коннектикут мужийн Вэстпорт дахь Алдарт зураачдын сургуульд багшилжээ. Энэ хугацаандаа тэрээр шар сэтгүүлд хэдэн зуун зураг чимэглэлийг хийсэн бөгөөд тэдгээр ажлын сэдэв нь маш өргөн хүрээтэй байсан хэдий ч ихэнх нь Вэстэрн хүмүүсийг дүрсэлдэг байв. Яваандаа тэр Нью Мексико руу нүүж, Санта Фегийн жим рүү харсан шавар байшинд суурьшаад Вэстэрн сэдвийг бүр ч илүү сонирхох болсон байна. Тэрээр бүтээлээ туурвихдаа маш нарийн судалгаа хийдэг бөгөөд Вэстэрн маягийн эд хэрэглэл, хувцас хунар, тухайн орон нутгийн өвс ургамал, газар зүйн онцлогийг бодитой дүрслэхийн тулд зурах гэж буй газраа зориуд очиж үздэг ажээ.

Америкийн Ковбой Зураачдын холбооны ууган гишүүний хувьд Жонсон тус байгууллагын ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байв. 1978–79 онуудад түүний тосон будгийн зургууд Аризона мужийн Финикст болсон Америкийн Ковбой зураачдын үзэсгэлэнгээс мөнгөн медаль хүртсэн байна. Тэрээр Парисын Гранд Паласт үзэсгэлэнгээ гаргаж, зургууд нь Америк, Мексик, Европт олон нийтийн болон хувийн олон цуглуулгад орсон байдаг. Сэтгүүлүүд Жонсоны тухай өгүүлэл нилээдийг нийтэлж, түүний зургууд хэд хэдэн номонд оржээ.



***Determination*, 1987**

Oil on canvas

30 3/4 x 40 3/4 in.

Courtesy of the artist and The Museum of Western Art, Kerrville, Texas

***Тэмүүлэл*, 1987**

Тосон будаг, зотон

78,1 x 103,5 см

Техас мужийн Кервилл дахь Вестэрн урлагийн музей болон уран бүтээлчийн бэлэг

Ted Long (born 1932)

Ted Long works from a studio in a century old log cabin in North Platte, Nebraska. Within sight of his house lie the historic plains where the Sioux, Cheyenne, and Pawnee Indian tribes followed the great buffalo herds around which their lives revolved. These same plains were also the scene of cattle stampedes, battles between the U.S. Cavalry and the Indians, and the migration of white settlers West in pursuit of land and new opportunities. *Winter in the Elk Horns* depicts a tribe in winter encampment.

Long was born in North Platte, Nebraska, and attended the town's high school where he received numerous art internships but no formal art training. Most of his work illustrates Western life and culture of the 1800s, with the subject matter of his paintings and sculpture being meticulously researched and realistically rendered in great detail. Long has immersed himself in the history and lore of the people who inhabited the West, from Buffalo Bill Cody to the famous Ponca Indian chief, Standing Bear.

In 1978 Long was commissioned by the Nebraska State Historical Society to do a life-sized bronze bust of Chief Standing Bear, and in 1979 he received the Old West Trails Foundation Art Award. In June 1991, Long's bronze entitled *When Nature Kept the Balance* was placed in the permanent collection of the Buffalo Bill Historical Center in Cody, Wyoming. The artist had the privilege of entertaining President Ronald Reagan at Long Ranch in 1987, at which time he presented the President with *The Last Farewell*, a bronze of Buffalo Bill Cody.

Тээд Лонг (1932)

Тээд Лонг Небраска мужийн Хойд Платт дахь зуун жилийн настай байшингийнхаа урланд уран бүтээлээ туурвидаг. Түүний байшингаас холгүй Сиү, Шаен, Поони индиан омгийнхон амьдралыг нь залгуулдаг одос үхрийн их сүргийг даган нүүдэллэж байсан түүхт тал харагддаг. Энэ тал бас үхэр сүрэг бужигнан үймж, Америкийн морьт цэргүүд индианчуудтай байлдаж, цагаан арьстнууд газар нутаг, шинэ боломж хайн Баруун хязгаар луу нүүдэллэж байхыг харсан билээ. *Элк Хорны* өвөл хэмээх энэхүү зурагт өвөлжөөндөө буусан омгийнхныг дүрсэлжээ.

Тэрээр Небраска мужийн Хойд Платтд төрсөн бөгөөд ахлах сургуульд сурч байхдаа зургийн дадлага нилээд хийсэн боловч мэргэжлийн боловсрол эзэмшээгүй юм. Түүний ихэнх бүтээлүүд нь 1800-гаад оны үеийн Вэстэрн амьдрал, соёлыг дүрсэлдэг бөгөөд зураг, баримлынхаа сэдвийг гүн гүнзгий судалж, маш нарийн урладаг. Баффало Билл Кодигоос эхлээд Понка индианчуудын алдарт удирдагч Босоо Баавгайг хүртэлх Баруун хязгаарын түүх, оршин сууж байсан хүмүүсийнх нь уламжлал заншилд Лонг татагджээ.

1978 онд тэрээр Небраска мужийн Түүхийн нийгэмлэгээс удирдагч Босоо Баавгайн цээж баримлыг хийх захиалга авсан бөгөөд 1979 онд *Old West Trails* сангийн шагнал авчээ. 1991 оны 7-р сард түүний *Байгаль тэнцвэртэй байх үед* нэртэй баримал нь Вайоминг мужийн Коди хот дахь Баффало Биллийн түүхийн төвийн байнгын цуглуулгад оржээ. Зураач 1987 онд өөрийн ранчодоо Ерөнхийлөгч Роналд Рейганыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх үедээ *Сүүлчийн үдэлт* нэртэй Баффало Билл Кодигийн баримлыг ерөнхийлөгчид бэлэглэжээ.



***Winter in the Elk Horns*, 1988**

Oil on canvas

25 x 40 in.

Courtesy of the artist and The Museum of Western Art, Kerrville, Texas

***Элк Хорны өвөл*, 1988**

Тосон будаг, зотон

63,5 x 101,6 см

Техас мужийн Кервилл дахь Вестэрн урлагийн музей болон
уран бүтээлчийн бэлэг

George Marks (1923-1983)

George Marks once stated: “As a life-long student of history, I believe that many facets of Western life remain to be pictured, and that the stage of the past is crowded with shadowy scenes and players, each awaiting a kindred spark.” Marks was an accurate and sensitive recorder of the American cowboy and his way of life for more than three decades. He was one of the earliest Cowboy Artists of America members, showing in the organizations first exhibition in 1966.

Born on a farm in Iowa’s Hardin County, Marks began sketching horses and cattle as a teenager. He did not decide to pursue a career in art, however, until after he finished a three-year stint in the Marine Corps. He then returned to his native Iowa and enrolled in the University of Iowa, receiving a Bachelor of Fine Arts degree in 1950. He attended graduate school for an additional year before beginning his career as a commercial artist.

During those years, Marks found that western themes were gradually coming to dominate his paintings and sculpture. He was spending summers and vacations in the West whenever possible to sketch and develop themes, and he found that the desire to move west continued to grow. In 1965 he moved to Albuquerque, New Mexico.

Жорж Маркс (1923-1983)

Жорж Маркс «Би бүхий л амдралынхаа турш түүх судалж байгаагийн хувьд өнгөрсөн хугацаанд сүүдэртэй бараан амьдрал, хүмүүсийг их дүрсэлдэг байсан бөгөөд вэстэрн амьдралыг урлагт олон талаас нь харуулж чадаагүй ч тэр цаг ирнэ гэдэгт итгэлтэй байна» гэж хэлсэн байдаг. Гуч гаруй жилийн турш Маркс Америкийн ковбойчууд болон өөрийнхөө амьдралыг бодитой бөгөөд мэдрэмжтэйгээр дүрслэн харуулж байв. Тэрээр Америкийн Ковбой Зураачдын холбооны анхны гишүүдийн нэг бөгөөд 1966 онд болсон анхны үзэсгэлэнд нь оролцож байв.

Айова мужийн Хардин дүүрэгт фермерийн гэр бүлд төрсөн Маркс бүр хүүхэд байхдаа л адуу мал зурж эхэлсэн байна. Тэр тэнгисийн явган цэрэгт 3 жил алба хааж дуусах хүртлээ урлагийн мэргэжил сонгох эсэхээ шийдээгүй байлаа. Цэргээс халагдаад төрөлх Айова мужид очиж, тэндхийн их сургуульд элсэн ороод 1950 онд Дүрслэх урлагийн бакалавр зэрэгтэй төгсжээ. Мэргэжлийн зураачаар ажиллаж эхлэхээсээ өмнө дахиад нэг жил дипломын дараахь сургалтанд хамрагдсан байна.

Тэр үед Маркс өөрийнхөө зураг, баримлуудад вэстэрн сэдэв давамгайлах болсныг анзаарсан байна. Тэрээр боломж гарах л юм бол зуны цагаар, эсвэл амралтаараа Баруун хязгаарт очиж зургийн сэдэв олох, хар зураг хийхээр явдаг байсан бөгөөд баруун зүг рүү нүүхийг улам их хүсэх болжээ. Тэрээр 1965 онд Нью Мексико мужийн Албукерки руу нүүжээ.



***Heading Home*, 1975**

Bronze

13 x 18 1/2 x 6 in.

Courtesy of the artist and The Museum of Western Art, Kerrville, Texas

***Гэртээ харих замд*, 1975**

Хүрэл

33 x 47 x 15,2 см

Техас мужийн Кервилл дахь Вэстэрн урлагийн музей болон уран бүтээлчийн бэлэг

William Moyers (born 1916)

One of the events that continues on the plains today is the battle between two male buffalo for the domination of the herd. This bronze depicts the fight that is taking place to determine which is the stronger, no matter what the price, with the survivor becoming the new leader. Each animal is instinctively driven to dominate the other, and there can be only one winner. *Price of the Herd* won the Gold Medal Award in 1972 at the Cowboy Artists of America show in Phoenix, Arizona. Moyers regards his art as an extension of human experience: “The basic elements of fine art, conflict, hunger, need, and the effects of weather ... anyone in the world during any age can understand.”

At the age of fourteen, Bill Moyers went to Colorado with his father, a lawyer, who placed him with a family of five boys on a ranch. He worked his way through high school and college as a cowboy, and began selling pictures of bucking horses for twenty-five cents each. Moyer graduated from Adams State Teachers College in Alamosa, Colorado, in 1939. He then devoted another year to art studies at the Otis Art Institute of Los Angeles, followed by experience as a commercial artist with Walt Disney Studios, working on the movie *Fantasia*. He also illustrated western classics for national publishers, but after more than a decade as an illustrator, decided to become a western artist and left the commercial field in 1962.

Moyers works in many media – oil paint, watercolor, dry brush, and bronze – and his highly realistic work in the tradition of Charles Russell and Frederic Remington has not gone unnoticed. It is held in the permanent collections of the Thomas Gilcrease Institute of American History and Art, Tulsa, Oklahoma; the National Cowboy Hall of Fame, Oklahoma City; the Museum of Western Art, Kerrville, Texas; the Sangre de Cristo Fine Arts Center, Pueblo, Colorado; and the Albuquerque Museum of Art and History, New Mexico. Moyer’s art has been exhibited at the Grand Palais in Paris, France, and the Beijing Exhibition Center in China.

Bill Moyers is a three-time president of the Cowboy Artists of America, of which he has been a member since 1968. He lives and works in Albuquerque, New Mexico.

Уильям Мойерз (1916)

Тал нутагт өнөө хүртэл болж байдаг нэг үйл явдал бол сүргийн манлай болохын төлөө үзэлцдэг бухнуудын тулалдаан билээ. Хэн илүү хүчтэй нь бөгөөд ямар ч үнээр хамаагүй амьд гарсан нь сүргийн шинэ манлай болохыг шийдвэрлэх тулааныг энэхүү баримал харуулжээ. Хоёр бухын аль аль нь зөнгөөрөө ялах хүсэлтэй ч нэг нь л ялагч болно. *Сүргийн үнэ цэнэ* 1972 онд Аризона мужийн Финикст болсон Америкийн Ковбой Зураачдын холбооны үзэсгэлэнгээс алтан медаль авсан байна. Мойерз өөрийн бүтээлүүдээрээ хүн төрөлхтний туршлагад нэмэр болж байна гэж үздэг. «Дүрслэх урлагийн үндсэн элементүүд, зөрчил, хүсэл, хэрэгцээ, цаг агаарын байдал ... дэлхий дээр амьдардаг ямар ч насны, хэн ч бай эдгээрийг ойлгож чадна».

14 настай байхдаа Билл Мойерз хуульч эцгийнхээ хамт Колорадод очсон бөгөөд эцэг нь түүнийг ранчо дээр амьдардаг 5 хүүтэй гэр бүлийнд орхисон байна. Тэрээр ахлах сургууль, коллежид сурч байх бүхий л хугацаандаа ферм дээр ажиллаж, булгиж буй морийг дүрсэлсэн зургуудаа нэг бүрийг нь 25 центээр зарж эхэлжээ. Мойерз 1939 онд Колорадо мужийн Аламоса хотод Багшийн коллеж төгсөөд Лос Анжелес хотноо Отисын Урлагийн сургуульд нэг жил суралцсан байна. Дараа нь Уолт Дисней студид *Уран сэтгэмж* хүүхэлдэйн кинон дээр ажиллаж бизнест хөл тавьсан юм. Мөн хэвлэлийн газрын захиалгаар вэстэрн сонгодог зохиолуудын зураг чимэглэлийг 10 гаруй жил хийж байгаад 1962 онд түүнийгээ орхин вэстэрн сэдвээр уран бүтээл туурвихаар санаа шулууджээ.

Мойерз тосон ба усан будаг, хуурай бийр, баримал зэрэг маш олон төрлөөр бүтээл хийдэг бөгөөд Чарльз Рассел, Фредерик Ремингтон нарын уламжлалыг хадгалсандээд зэргийн реалист бүтээлүүд нь хүмүүсийн анхаарлыг татсан юм. Түүний бүтээлүүд Охлахома мужийн Тулса дахь Томас Гилкризын Америкийн түүх, урлагийн институт, Оклахома хотын Ковбой урлагийн үндэсний танхим, Техас мужийн Кервилл дахь Вэстэрн урлагийн музей, Колорадо мужийн Пуэбло хотын Сангре дэ Кристо Дүрслэх урлагийн төв, Нью Мексико мужийн Албукеркийн Түүх, урлагийн музей зэрэг олон газрын байнгын цуглуулганд байдаг. Мойерзийн бүтээлүүд Францын Парис хотноо Гранд Палас, Хятадын Бээжин хотын Үзэсгэлэнгийн танхимд тавигдаж байжээ.

Билл Мойерз 1968 онд Америкийн Ковбой Зураачдын холбооны гишүүн болж, тус байгууллагын ерөнхийлөгчөөр 3 удаа сонгогдсон байна. Одоо тэрээр Нью Мексико мужийн Албукерки хотод амьдарч, уран бүтээлээ туурвиж байна.



***Price of the Herd*, 1972**

Bronze

12 1/2 x 15 3/4 x 10 1/2 in.

Courtesy of the artist and The Museum of Western Art, Kerrville, Texas

***Сүргийн үнэ цэнэ*, 1972**

Хүрэл

31,8 x 40 x 26,7 см

Техас мужийн Кервилл дахь Вэстэрн урлагийн музей болон уран бүтээлчийн бэлэг

Gary Niblett (born 1943)

Trail Dust depicts cowboys driving a herd of cattle to the railhead, where the animals will be loaded onto freight cars. Their noses and mouths covered with bandanas, the cowboys inevitably end up covered from head to foot with the dust that swirls around them as they work to earn their pay.

Gary Niblett was born and raised in Carlsbad, New Mexico. After graduating from high school, he went to California, where he attended the Art Center College of Design in Pasadena. He spent eight years with the Hanna-Barbera Animation studios as a background artist, but continued to develop his own style. In 1973 Niblett left commercial art to focus exclusively on western art, and three years later was voted into the Cowboy Artists of America. He returned to New Mexico, where he continued to gain national recognition

Niblett's work has been exhibited all over the world, including in the Grand Palais, Paris, France, and the Amerika Haus Berlin, Germany. He has also exhibited in Moscow, Russia; Taipei, Taiwan; and Beijing, China, and with the prestigious Royal Watercolor Society, London, England. Niblett's work has been included in publications such as the *International Fine Art Collector*, *Time*, *Saturday Review*, and *New Mexico Magazine*. He was honored as the 1990 Distinguished Calendar Artist for *New Mexico Magazine*, as well as in a book entitled *Gary Niblett – A New Look at the Old West*. One of his large oil paintings graces the State Capitol building in Santa Fe, New Mexico.

Гари Ниблетт (1943)

Энэ зураг дээр өртөө рүү аваачиж вагонд ачуулах малаа тууж яваа ковбой нарыг дүрсэлжээ. Хамар, амаа бандана алчуураар битүү боосон тэд мөнгө олохоор ийнхүү явахдаа яах ч аргагүй толгойноосоо хөлөө хүртэл тоосонд даруулжээ.

Гари Ниблетт Нью Мексико мужийн Карлсбад хотод төрж өсчээ. Ахлах сургуулиа төгсөөд Калифорнид очиж Пасадена дахь Дизайн урлагийн коллежид суралцжээ. Тэрээр 8 жилийн турш Ханна-Барбера хүүхэлдэйн киноны студид фоны зураачаар ажиллах хугацаандаа өөрийн гэсэн хэв маягаа хөгжүүлсээр байв. Вэстэрн урлагт өөрийгөө зориулахаар шийдсэн тэрээр 1973 онд ажлаа орхиж, улмаар 3 жилийн дараа Америкийн Ковбой Зураачдын холбоонд элссэн байна. Нью Мексикод буцаж очсоноос нь хойш үндэсний хэмжээнд нэр алдар нь өссөөр байлаа.

Ниблеттийн бүтээлүүд Парисын Гранд Палас, Берлиний Америка Хаус зэрэг олон газруудад тавигджээ. Москва, Тайпэй, Бээжин, маш их нэр хүнд бүхий Лондон дахь Эзэн хааны Усан будгийн зургийн нийгэмлэгт хүртэл үзэсгэлэн нь гарч байв. Түүний бүтээлүүд *Тайм* сэтгүүлийн Бямба гарагийн дугаарт нийтлэгддэг *Олон улсын дүрслэх урлагийн цуглуулга* тойм, мөн *Нью Мексико* сэтгүүлд тавигдаж байв. 1990 онд түүнийг *Нью Мексико* сэтгүүл болон *Гари Ниблетт-хуучин Баруун хязгаарыг шинээр харахуй* хэмээх номонд Оны тэргүүний хуанлийн зураачаар нэрлэжээ. Түүний томоохон тосон будгийн зургуудын нэг нь Нью Мексико мужийн Санта Фе дахь Төрийн Капитол ордныг чимж байдаг.



***Trail Dust*, 1988**

Oil on canvas

17 ½ x 40 ½ in.

Courtesy of the artist and The Museum of Western Art, Kerrville, Texas

***Замын тоос*, 1988**

Тосон будаг, зотон

44,5 x 102,9 см

Техас мужийн Кервилл дахь Вестерн урлагийн музей болон
уран бүтээлчийн бэлэг

Kenneth Riley (born 1919)

High Country Traveler depicts a single traveler on horseback making his way across a Western landscape. He'll undoubtedly face many challenges as he continues his journey, intent on getting to the destination that he will ultimately call "home."

Born in Missouri and raised in Kansas, Ken Riley went to the Kansas City Art Institute to study with Thomas Hart Benton in 1938. In 1941 he moved on to the Art Students League in New York City, with evening classes at the Grand Central School of Art. Soon Riley was selling illustrations to *National Geographic*, *Life*, *The Saturday Evening Post*, and other national publications.

On assignment for the National Park Service in 1967, Riley found himself in Yellowstone and the Grand Tetons. He says that the intensity of the light "probably triggered the whole excitement about coming to the West, especially the breaking light, when you could see patterns. When you get into a big space with immense patterns moving across the countryside, it's unbelievable. Trying to get some of these effects is a lifetime right there."

Riley works primarily in oil and acrylic paint, and depicts those people who inhabited and changed the land: the native peoples of the West and the U.S. Army cavalry. Riley was elected to the Cowboy Artists of America in 1982, and he is a charter member of the National Academy of Western Art, Oklahoma City, Oklahoma. His paintings can be found in the permanent collections of the United States Military Academy's West Point Museum, New York; the White House collection and the Smithsonian Institution, both in Washington, D.C.; the Custer Battlefield Museum, Garryowen, Montana; DePauw University, Greencastle, Indiana; and the Phoenix Art Museum, Arizona. In 1995 he received the Prix de West Award at the National Cowboy Hall of Fame in Oklahoma City. The Eiteljorg Museum in Indianapolis, Indiana, recently commissioned a painting for their permanent collection.

Кэннэт Райли (1919)

Уулын аянчин хэмээх энэхүү зурагт Баруун хязгаар нутгийг туулж яваа ганц морьтныг дүрсэлжээ. Аян зам нь холдох тутам олон бэрхшээл тулгарах нь дамжиггүй ч тэрээр зорьсон газраа хүрэхээр зориг шулууджээ.

Миссурид төрж, Канзаст өссөн Кэн Райли 1938 онд Канзас хотын Урлагийн дээд сургуульд Томас Харт Бен-тоноос суралцахаар элсжээ. 1941 онд тэрээр Нью-Йорк хотын Урлагийн Оюутны лигт элсэж, оройн цагаар Гранд Сэнтрал Урлагийн сургуульд явж байв. Удалгүй Райли *National Geographic*, *Life*, *The Saturday Evening Post* болон бусад үндэсний хэвлэлүүдэд зураг чимэглэл хийж эхэлсэн байна.

Райли 1967 онд Үндэсний Паркийн даалгавраар Елоустун болон Гранд Титонд очсон байна. Тэрээр «Баруун хязгаарт очихын гол утга учир нь янз бүрийн дүрс хээ харагддаг тэрхүү нүд гялбам хурц гэрэлд байдаг. Өргөн талд зэрэглээ сүүмэлзэхийг хараад итгэхийн аргагүй бөгөөд түүнийг дүрсэлж үзүүлэх нь амьд явсны хэрэг билээ» гэж хэлдэг.

Райли голдуу тосон ба акрил будгаар зурдаг бөгөөд Баруун хязгаарт суурьшиж, түүний өнгө төрхийг өөрчилсөөр ирсэн уугуул нутгийнхныг, [АНУ-ын армийн] морьт цэргүүдийг зурдаг. 1982 онд Райли Америкийн Ковбой Зураачдын холбоонд элссэн бөгөөд Оклахома хотын Вэстэрн урлагийн үндэсний академийг үндэслэгчдийн нэг юм. Түүний бүтээлүүдийг Нью-Йорк дахь АНУ-ын Цэргийн академийн Вэстпойнт музей, Вашингтон дахь Цагаан ордон, мөн Смитсоны хүрээлэн, Монтана мужийн Гарриовен дахь Кастер Батлфильд музей, Индиана мужийн Грийнкастл дахь Де Поо их сургууль, Аризона мужийн Финиксийн урлагийн музей зэрэг олон газар харж болно. 1995 онд тэрээр Оклахома хотын Үндэсний ковбой урлагийн үзэсгэлэнгээс *Prix de West* шагналыг авчээ. Саяхан Индиана мужийн Индианаполис дахь Айтэлийоргийн музей байнгын цуглуулгадаа авах зорилгоор нэг зураг захиалсан байна.



***High Country Traveler*, 1973**

Oil on canvas

24 $\frac{3}{4}$ x 28 $\frac{3}{4}$ in.

Courtesy of the artist and The Museum of Western Art, Kerrville, Texas

***Уулын аянчин*, 1973**

Тосон будаг, зотон

62,9 x 73 см

Техас мужийн Кервилл дахь Вестэрн урлагийн музей болон уран бүтээлчийн бэлэг

Grant Speed (born 1930)

“Dust storms are very common in the West. In certain areas and at dry times, these storms can be severe and last for several days. Blowing sand can be uncomfortable at times, even painful, with visibility sometimes being cut to almost nothing. They can hit suddenly and catch cowboys while they are working or driving cattle. The work cannot stop until it is finished, so men and animals must endure these storms from time to time and persevere.

This bronze shows a cowboy with a neckerchief over his face to cut down on the dust he inhales, as well as to protect his face some. After hours of pushing cattle, hollering through the neckerchief with the wind forcing the cloth back into the rider’s mouth, it becomes moist and begins to stick to lips and face.”

Grant Speed

When asked how he became a sculptor, Grant Speed replied that he was born with the desire to draw and sculpt. It wasn’t until many years later, however, after working on ranches throughout the West, riding in rodeos, getting married, and becoming a father, that he sat down to see what would happen. He devoted nights and weekends to creating Western art and, in a few years, he quit his day job to pursue bronze sculpture full-time. Since there were few foundries in the 1960s, Speed did everything, from modeling right down to the final casting.

In 1966 Grant became one of the Charter Members of the Cowboy Artists of America (CAA) organization, and over the years he has served as president and director. He considers his CAA Gold and Silver awards among the most important recognition he has received during his career. Speed has participated in numerous one-man, two-man, and group art shows, with his largest shows in 1992, exhibiting seventy-six bronzes in Salt Lake City, Utah, and eighty pieces in Dallas, Texas.

In 2000 the artist completed a monument depicting the Texas Tech University mascot, *The Red Raider*, with a life-sized horse and rider. He has recently created a larger-than-life bronze of a Texas longhorn steer.

Grant’s work is in numerous public and private collections throughout the United States and abroad; it can be seen in books and other publications, including a biography by Western writer Don Hedgpeth entitled *From Broncs to Bronzes* (Northland Press, 1979). Grant lives and works in Lindon, Utah.

Грант Спид (1930)

«Баруун хязгаарт шороон шуурга их элбэг тохиолддог. Хур тунадасгүй үед зарим газар ийм шуурга маш хүчтэй болдог бөгөөд хэд хоногоор үргэлжилнэ. Нүүр нүдгүй шавхуурдах элс зарим тохиолдолд бүр юу ч харагдахгүй болтол шуурна. Ийм шуурга адуу малаа тууж, ахуй амьдралаа залгуулж яваа ковбойчуудыг гэнэт л нөмрөн орж ирнэ. Ажлаа дуустал хийх ёстой болохоор хүн, малгүй л энэ шуургыг сөрөн зогсож, даван гарах хэрэгтэй болдог.

Энэхүү баримал ам хамар руу нь зай завсаргүй чихэх элс шороог хааж, нүүрээ бага боловч хамгаалах гэж алчуур боосон ковбойг дүрсэлжээ. «Хэдэн цагийн турш хашгичиж гуагчин малаа туусаар явахад нүүрээ боосон алчуур нь шал нойтон болж, нүүр аманд наалдаж эхэлнэ».

Грант Спид

Яаж уран барималч болсон бэ гэж асуухад Грант Спид ер нь л зураг зурах, баримал хийх хүсэлтэй төрсөн гэж хариулдаг. Гэхдээ Баруун хязгаарт ранчо дээр ажиллаж, родеод уралдаж, гэрлэж, аав болсныхоо дараа уран бүтээл хийж эхлэхээр шийдэх хүртэл нилээд олон жил өнгөрсөн байлаа. Унтах нойроо хугаслан, амралтын өдрүүдээ Вэстэрн маягийн бүтээл туурвихад зориулж байлаа. Хэдхэн жилийн дараа тэрээр мэргэжлийн уран барималч болохоор бүрмөсөн шийдэж өдрийн ажлаа орхив. 1960-аад онд цутгамалын цех бараг байдаггүй байсан болохоор Спид баримлынхаа загварыг гаргахаас эхлээд цутгах хүртэл бүх зүйлийг өөрөө хийдэг байв.

Грант 1966 онд Америкийн ковбой зураачдын холбооны үндэслэгчдийн нэг болж, нилээд хэдэн жил энэ байгууллагын ерөнхийлөгч болон захирлаар нь ажилласан байна. Тус холбооноос хүртсэн алт, мөнгөн медалиудаа амьдралынхаа туршид авсан хамгийн чухал шагналуудын нэг гэж тэр үздэг. Спид бие даасан, хоёр хүний болон хэсэгчилсэн үзэсгэлэнгүүдэд удаа дараа оролцож байсан бөгөөд 1992 онд Юта мужийн Солт Лэйк хотод 76 ширхэг, Техас мужийн Даллас хотод 80 ширхэг бүтээлээ дэлгэн үзүүлсэн нь хамгийн том 2 үзэсгэлэн нь байлаа.

2000 онд тэрээр Техасын Техникийн их сургуулийн бэлэгдлийг дүрсэлсэн, морь болон хүнийг бодит хэмжээгээр нь цутгасан *Улаан морьтон* хөшөөг хийж дуусгажээ. Саяхан тэрээр Техасын данхар эвэрт шар үхрийн том хэмжээний баримлыг хийсэн байна.

Грантын олон бүтээл Америк орон даяар, мөн гадаад орнуудад олон нийтийн болон хувийн цуглуулгад байдаг. Вэстэрн сэдвээр бичдэг зохиолч Дон Хэжпэтийн *Зэрлэг адуунаас хүрэл баримал хүртэл* (Northland Press, 1979)



***In a Howling Dust Storm*, 2004**

Bronze

15 x 11 x 13 in.

Courtesy of the artist and The Museum of Western Art,
Kerrville, Texas

***Шороон шуурга улихуй*, 2004**

Хүрэл

38,1 x 27,9 x 33 см

Техас мужийн Кервилл дахь Вэстэрн урлагийн музей
болон уран бүтээлчийн бэлэг

нэртэй намтар зохиолоос эхлээд олон ном, сэтгүүлүүдээс түүний бүтээлийг харж болно. Грант одоо Юта мужийн Линдон хотод амьдарч, уран бүтээлээ туурвиж байна.

Fritz White (born 1930)

“From ocean to ocean, across the entire continent of North America, as far to the south as the Rio Grande, the buffalo provided life to the first American Pioneers. Every family, every tribe, knew what to do with the carcass of the Bison. The animal provided food, clothing, and shelter, but it also gave people oil, glue, tools, weapons, rattles, tanning supplies, and more. The buffalo was revered so, and a tradition of prayer accompanies the harvesting of buffalo. Each society had its ‘buffalo dance.’ Some performed before the hunt in hopes of plenty, some performed after the hunt to give thanks. This bronze depicts the dance of the Mandan Tribe from the Missouri Valley of the lower South Dakota plains.”

Fritz White

Fritz White was born January 14, 1930, in Milford, Ohio, near Cincinnati. The Little Miami River, which borders Cincinnati on the east, was a main thoroughfare north and south for the Shawnee tribes that settled throughout Ohio. Artifacts of the Shawnees, Miamis, Mingos, and even mound builders were common to the area. It was by these artifacts that his interest in Native American culture and mythology was kindled.

White joined the Cowboy Artists of America in 1972. He recalls that: “As a kid, I used to think that, when I followed a path along the river, the Shawnee had been there only moments ago. Perhaps my need to depict American Indians came from all the stories I had heard and read growing up. That interest and feeling has grown dramatically with my research into the day-to-day life of the American Indian. The thrill comes from exploring one small facet of life after another. We, as observers, have barely begun to tell their story. We will never be able to tell the entire saga of the thousands of years of their civilizations.”

Фриц Уайт (1930)

«Нэг далайн эргээс нөгөөг хүртэл, Хойд Америк даяар, өмнө зүгт Рио Гранде хүртэлх уудам нутагт одос үхэр Америкт анхлан суурьшигчдын амьдралыг залгуулж байлаа. Айл, омог бүр түүнийг яаж бүрэн ашиглахаа мэддэг байв. Энэ амьтан хоол хүнс, хувцас хунар, орон байр төдийгүй тос, цавуу, багаж, зэвсэг, хөгжмийн зэмсэг, арьс шир болон бусад зүйлийг хүмүүст өгдөг байв. Тийм болохоор одос үхэрт маш хүндэтгэлтэй хандаж, түүний авд мордохдоо мөргөл тахилга үйлддэг байв. Омог бүр өөрийн гэсэн «одос үхрийн бүжиг»-тэй байсан бөгөөд зарим нь анд гарахын өмнө ангийн хишиг гуйж, нөгөө хэсэг нь ан аваа дуусгаад талархалаа илэрхийлж хийдэг байжээ. Энэхүү баримал нь Өмнөд Дакотагийн нам дор газар, Миссурийн хөндий хавьд байсан Мандаан омгийн бүжгийг харуулж байна.

Фриц Уайт

Фриц Уайт 1930 оны 1-р сарын 14-нд Охайо мужийн Милфорд хотод төржээ. Зүүн талаараа Синсинатитэй хиллэдэг Бага Майами гол нь Охайо муж даяар суурьшсан Шооний омгуудын хувьд хойд ба өмнө зүг рүү гарах гол гарц нь байв. Энэ нутагт Шооний, Майами, Минго омгууд болон «хиргисүүр бүтээгч» нарын гар урлал их түгээмэл байсан нь Уайтыг уугуул Америкчуудын соёл, үлгэр домгийг сонирхоход хүргэсэн байна.

1972 онд Уайт Америкийн Ковбой Зураачдын холбоонд элсчээ. Тэрээр хожим дурсахдаа «Хүүхэд байхдаа би голын эрэг дагуух жимээр явж байхдаа дөнгөж саяхан тэнд Шооний омгийнхон байсан мэтээр төсөөлдөг байв. Америкийн индианчуудыг уран бүтээлдээ дүрслэх гэж хүсдэг нь багадаа сонссон бүхэнтэй минь холбоотой байх. Америкийн индианчуудын өдөр тутмын амьдралыг судалж эхэлснээс хойш миний тэр хүсэл, сонирхол улам бүр ихэссэн билээ. Амьдралын өчүүхэн жижиг юмсыг бага багаар судалж мэдэх бүрт баяр хөөр ирдэг юм. Хөндлөнгөөс ажиглагчийн хувьд бид тэдний түүхийг дөнгөж л өгүүлж эхэлж байна. Тэдний хэдэн мянган жилийн соёл иргэншлийн түүхийг бүхэлд нь өгүүлж бид хэзээ ч чадахгүй».



To Honor the Buffalo Dance, undated
Bronze
15 x 16 ½ in.
Courtesy of the artist and
The Museum of Western Art, Kerrville, Texas

Одос үхрийн хүндэтгэлийн бүжиг,
он нь тодорхойгүй
Хүрэл
38,1 x 41,9 см
Техас мужийн Кервилл дахь Вестэрн урлагийн
мүзей болон уран бүтээлчийн бэлэг

Acknowledgments

Washington

Anne Johnson, Director, ART in Embassies Program
Virginia Shore, Curator
Imtiaz Hafiz, Assistant Curator
Rebecca Clark, Registrar
Marcia Mayo, Publications Editor
Sally Mansfield, Publications Projects Coordinator
Patrick Brown, Cover Design

With special thanks to Guest Curator Richard Assunto,
Executive Director of The Museum of Western Art in Kerrville, Texas.

Ulaanbaatar

U.S. Embassy, Ulaanbaatar
Denver Herren, Management Officer
David Bodycoat, Facilities Maintenance Officer
Scott Weinhold, Public Affairs Officer
Ch.Tuul, Translator
P. Tina, Information Assistant
B. Toshka, Photographer

Vienna

Claudia Kupfer, Graphic Design

Талархал

Вашингтон

Энн Жонсон, «ЭСЯмд дахь уран зураг» хөтөлбөрийн захирал
Виржиниа Шоор, музейн эрдэм шинжилгээний ажилтан
Имтиаз Хафиз, музейн эрдэм шинжилгээний туслах ажилтан
Ребекка Кларк, бүртгэгч
Марсиа Майо, хэвлэлийн редактор
Салли Мэнсфилд, хэвлэлийн төслийн зохицуулагч
Пэтрик Браун, хавтасны дизайнер

Техас мужийн Кервилл дахь Вэстэрн урлагийн музейн эрхлэгч,
гүйцэтгэх захирал Ричард Ассунтод гүн талархалаа илэрхийлье.

Улаанбаатар

АНУ-ын Элчин сайдын яам
Дэнвэр Хэррэн, удирдах ажилтан
Дэвид Бодикоут, барилгын засвар үйлчилгээ хариуцсан ажилтан
Скот Вайнхолд, олон нийттэй харилцах асуудал эрхэлсэн ажилтан
Ч. Туул, орчуулагч
П. Тина, мэдээлэлийн туслах ажилтан
Б. Ташка, гэрэл зурагчин

Вена

Клаудиа Купфер, график дизайнер



Published by the ART in Embassies Program
U.S. Department of State, Washington, D.C.
February 2005